

БАТЛАВ  
БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА И.БАТТӨГС

2024 оны .... дугаар сарын ...

АЙЛ ӨРХ, АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАН ЯЛГАЛТ,  
АЧИЛТ, ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ,  
ҮНЭЛЭЛТ ДҮГНЭЛТ ӨГӨХ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨХ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.05.10

Улаанбаатар хот

Ажлын цар хүрээ:

Баянзүрх дүүргийн айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын ангилан ялгалт, ачилт, цуглуулалт, тээвэрлэлтийн ажлын гэрээт хугацаанд “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын дагуу хяналт тавьж, үнэлэх, дүгнэх, гүйцэтгэгчийг мэргэжил, арга зүйгээр хангах, зөвлөмж, дүгнэлт өгөх, холбогдох стандарт шаардлагыг хангуулж, гүйцэтгэл, үр дүнг тайлагнаж, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам стандартын зааврыг мөрдлөг болгоно.

Зөвлөх үйлчилгээний нэр	Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын ангилан ялгалт, ачилт, цуглуулалт, тээвэрлэлтийн ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх захиалагчийн хяналт хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээний ажил
Захиалагч байгууллага	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар
Зорилго	Хог тээврийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад дэмжлэг үзүүлэх, үйлчилгээнд хяналт тавих, хог хаягдал ангилан ялгах, цуглуулалт, тээвэрлэлтийн ажилд арга зүйн зөвлөгөө өгөх, дүгнэлт хийх, хяналт тавих, үр дүнг үнэлэх
Үндэслэл, хэрэгцээ шаардлага	<ul style="list-style-type: none"><li>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”</li><li>Нийслэлийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Чиг үүрэг шилжүүлэх тухай” А/1461 дүгээр захирамж</li><li>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн “Чиг үүрэг шилжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/293 дугаар тушаал</li></ul>
Хугацаа	Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
Ажлын хамрах хүрээ	Зөвлөх нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд: 1. Төлөвлөгөөний биелэлт, үүрэг даалгаврын хэрэгжилтэд үнэлгээ өгөх, тайлагнах 2. Хог хаягдал цуглуулалт, тээвэрлэлтийн хуваарь, дуудлагын хэрэгжилтэд хяналт тавьж, баримтжуулах 3. Гэрээт аж ахуйн нэгж, байгууллагууд болон захиалагч байгууллагыг мэдээллээр хангах зорилгоор өдөр тутмын хийсэн ажилбарын мэдээнд тогтмол хяналт тавин ажиллах 4. Гарсан зөрчлийг илрүүлж, акт тогтоож захиалагч байгууллагад хүргүүлэх

	<ol style="list-style-type: none"> <li>5. Гэрээт аж ахуйн, нэгж байгууллагуудын сар бүрийн ажлын гүйцэтгэлийг хянан дүгнэж, захиалагч байгууллагад хүргүүлэх</li> <li>6. Захиалагчаас зарласан цаг үеийн шаардлагатай хуралд оролцох, тайлан танилцуулга бэлтгэх</li> <li>7. Захиалагчид улирал бүр хийсэн ажлын танилцуулгыг бэлтгэж, танилцуулах</li> <li>8. Талбайд ажиллаж байгаа аж ахуйн, нэгж болон ажилчдын ажлын байрны анхан шатны зааварчилгаа авч ажиллаж байгаа эсэхэд хяналт тавих</li> <li>9. Хур болон үүсмэл хогийн цэгүүдийн бүртгэл гаргах, устгах арга хэмжээ зохион байгуулах, баримтжуулах, дүн шинжилгээ хийх</li> <li>10. Иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлагнах</li> <li>11. Хог хаягдлын олон нийтийн байцаагчийг чадавхижуулах, үнэлэх, илэрсэн зөрчлийн арилгуулах арга хэмжээ авах</li> <li>12. Бүх нийтийн их цэвэрлэгээний үйл ажиллагаанд хяналт тавих, цэвэрлэгээнд оролцоогүй, зөрчилтэй аж ахуйн нэгж байгууллагуудад мэдэгдэх хуудас өгөх, бүртгэх, зөрчлийг арилгуулах</li> <li>13. Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах ажлыг эрчимжүүлэх, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах, үнэлэлт дүгнэлт өгөх</li> <li>14. Менежмент сайжруулах төлөвлөгөө, зөвлөмж боловсруулах</li> <li>15. Ариутгал, халдваргүйтгэлийн ажилд хяналт тавих</li> <li>16. Аж ахуйн нэгж байгууллага, иргэдээс хог хаягдал цуглуулалт, цэвэрлэгээ, тээвэрлэлтийн сэтгэл ханамжийн судалгаа гаргах, үр дүнг танилцуулах, санал боловсруулах</li> <li>17. Илэрсэн зөрчил дутагдал, үүсэж болзошгүй асуудлын шийдлийг тодорхойлж арилгуулах, санал оруулах</li> <li>18. Захиалагч байгууллагаас цаг үеийн шаардлагаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг цаг тухай бүрд мэдээлэх, бүртгэл хөтлөх</li> </ol>																		
<p>Зөвлөхөд тавигдах шаардлага</p>	<p>Хөндлөнгийн хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагад дараах шаардлагууд тавигдана.</p> <table border="1" data-bbox="551 1310 1449 1619"> <thead> <tr> <th>Албан тушаал</th> <th>Тоо</th> <th>Сургалт</th> <th>Туршлага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Удирдлага</td> <td>1</td> <td rowspan="3">Ажилтнууд нь хог хаягдлын менежментийн чиглэлээр гэрчилгээтэй сургалтанд хамрагдсан байх</td> <td>1. Хог хаягдлын салбарт 4-өөс доошгүй жил ажилласан байх</td> </tr> <tr> <td>Захиргааны ажилтан</td> <td>1</td> <td>2. Судалгаа, мониторинг, үнэлгээгээр мэргэшсэн байх</td> </tr> <tr> <td>Хяналтын ажилтан</td> <td>3</td> <td>3. Ажлын байр, ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, машинтай байх</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td></td> <td>4. Хяналт үнэлгээний чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан туршлагатай байх</td> </tr> </tbody> </table>	Албан тушаал	Тоо	Сургалт	Туршлага	Удирдлага	1	Ажилтнууд нь хог хаягдлын менежментийн чиглэлээр гэрчилгээтэй сургалтанд хамрагдсан байх	1. Хог хаягдлын салбарт 4-өөс доошгүй жил ажилласан байх	Захиргааны ажилтан	1	2. Судалгаа, мониторинг, үнэлгээгээр мэргэшсэн байх	Хяналтын ажилтан	3	3. Ажлын байр, ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, машинтай байх				4. Хяналт үнэлгээний чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан туршлагатай байх
Албан тушаал	Тоо	Сургалт	Туршлага																
Удирдлага	1	Ажилтнууд нь хог хаягдлын менежментийн чиглэлээр гэрчилгээтэй сургалтанд хамрагдсан байх	1. Хог хаягдлын салбарт 4-өөс доошгүй жил ажилласан байх																
Захиргааны ажилтан	1		2. Судалгаа, мониторинг, үнэлгээгээр мэргэшсэн байх																
Хяналтын ажилтан	3		3. Ажлын байр, ажилд шаардлагатай тоног төхөөрөмж, машинтай байх																
			4. Хяналт үнэлгээний чиглэлээр төрийн байгууллагатай хамтран ажилласан туршлагатай байх																
<p>Төсөв</p>	<p>Санхүүжилт нь айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зардлын захиалагчийн хяналтын зардал байна.</p>																		
<p>Хог хаягдал цуглуулалт, ачиж тээвэрлэх ажилд мөрдөгдөж буй стандарт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын 2020 оны “Энгийн хог хаягдлыг, ангилах, цуглуулах тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах булшлах журам” 32/03 дугаар тогтоол</li> <li>• Зам талбайн үйлчлэгч, ачигч, тээврийн ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны удирдамж UCS1704A</li> <li>• Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент UCS1701A</li> </ul>																		
<p>Үр дүнг тайлагнах</p>	<p>Зөвлөх үйлчилгээ үзүүлсэн зөвлөх нь Захиалагчаас өгөх чиглэл, зааврын дагуу ажиллана.</p>																		

	Сар бүр гүйцэтгэлийн тайлан, үнэлгээ, түүнтэй холбогдох баримт бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж ажиллана.
--	--

ХЯНАСАН:

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА

  
Н.БИЛЭГСАЙХАН

БОЛОВСРУУЛСАН:

АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ  
ТАСГИЙН ДАРГА

  
М.БАТ-ЭРДЭНЭ